

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч тодорхойлолт	3
1.2. Төслийн байршил	4
1.3. Ордын геологийн нөөц.....	5
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим.....	6
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал	6
БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
2.1. Уул зүй.....	7
2.2. Усан сүлжээ.....	8
2.3. Уур амьсгал.....	8
2.4. Ургамалан нөмрөг.....	8
2.5. Хөрсөн бүрхэвч	9
2.6. Ан амьтад.....	10
2.7. Хүн ам, дэд бүтэц, эдийн засаг	11
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
3.1. Агаарын чанарт нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	12
3.2. Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	12
3.3. Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	12
3.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	13
3.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	13
БҮЛЭГ-4. “ХОЙД ӨНДӨР ХОШУУ-1” ЭЛСНИЙ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	14
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө...21	
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	24
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	27
4.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл.....	28
ДҮГНЭЛТ	29
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт, үндсэн үзүүлэлтүүд.....	3
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 3. “Хойд өндөр хошуу-1” барилгын элсний ордын батлагдсан геологийн нөөц.....	5
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим, хүчин чадал	6
Хүснэгт 5. Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал .	7
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	4
---	---

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт, үндсэн үзүүлэлтүүд


№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2024 онд	Ашиглалтын хугацаанд
А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ				
1	Тусгай зөвшөөрлийн дугаар	-	MV-46000205	
2	Ордын байршил	-	Өмнөговь, Ханбогд	
3	Орд ашиглалтын хугацаа	жил	3	
Б. ОРДЫН НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ				
4	Ордын батлагдсан геологийн нөөц (B+C)	мян.м ³	301.65	
5	Уурхайлалтад өртөх нөөц (B+C)	мян.м ³	212.12	
6	Хаягдлын хэмжээ	%	5.45	
7	Үйлдвэрлэлийн нөөц	мян.м ³	200.55	
В. УУРХАЙН ОЛБОРЛОЛТ, БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТ				
8	Элс олборлолт	мян.м ³	70.0	200.55
9	Хөрс хуулалт	мян.м ³	9.09	26.04
10	Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр	м ³ /м ³	0.13	0.13
11	Уурхайн ашиглалтын систем	Авто тээвэртэй		
12	Бүтээгдэхүүн гаргалт	мян.м ³	70.0	200.55
Г. ҮНДСЭН ТЕХНИК-ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД				
13	Автосамосвал (Howo ZZ3167), Q - 8 м ³	ш	Түрээс - 4	
14	Утгуурт ачигч (LiuGong ZL30E), E - 1.5 м ³	ш	Түрээс - 1	
Д. ДЭД БҮТЭЦ				
15	Цахилгааны эх үүсвэр	-	Дизель генератор	
16	Усны хэрэглээ	мян.м ³	8.68	25.63
17	Усны эх үүсвэр	-	Гүний худаг, зөөвөр	
Е. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
18	Төслийн хөрөнгө оруулалт	сая төг	325.40	-
19	Ажиллагсдын тоо	хүн	21	
20	Ажиллагсдын дундаж цалин	мян.төг	1,513.10	
21	Бүтээгдэхүүн борлуулалт	мян.м ³	70.0	200.55
22	Борлуулалтын орлого	сая төг	1,295.00	3,710.18
23	Олборлолт, үйл ажиллагааны зардал	сая төг	966.25	2,794.74
24	Төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөрүүд	сая төг	326.73	950.98
25	Үүнээс: ТТАМНАТ	сая төг	32.38	92.75
26	ААНОАТ	сая төг	32.88	25.80
27	Цэвэр ашиг	сая төг	295.88	823.90
28	Төслийн өнөөгийн үнэ цэнэ (NPV, i=10%)	сая төг	555.51	
29	Хөрөнгө оруулалтын өгөөжийн норм (IRR)	%	90.84	
30	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	1.04	
31	1 м ³ элсний бүрэн өөрийн өртөг	төгрөг	13,935.36	

1.2. Төслийн байршил

“Дэйзэрт бридж” ХХК-ийн эзэмшлийн MV-46000205 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь “Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 890 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн урагш 327 км, Ханбогд сумын төвөөс зүүн урагш 67 км, Тавантолгой-Манлай-Ханги чиглэлд төлөвлөж буй авто замаас баруун урагш 7 км зайд, 1:50'000-ны масштабын байр зүйн зургийн K-49-25-A тоот хавтгайд байрлана. Ордын төв цэгийн солбилцол нь зүүн уртрагийн $108^{\circ} 02' 08.55''$, хойд өргөргийн $43^{\circ} 12' 44.19''$ байна.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Цэгийн дугаар	Газарзүйн систем (WGS-84)						Метрийн систем (UTM)	
	Уртраг			Өргөрөг			Уртраг	Өргөрөг
	град	мин	сек	град	мин	сек	метр	метр
1	108	2	28.00	43	12	11.50	259615.23	4787630.81
2	108	2	28.00	43	12	50.00	259657.26	4788818.55
3	108	1	50.00	43	12	50.00	258799.81	4788848.95
4	108	1	50.00	43	12	11.50	258757.63	4787661.21



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

1.3. Ордын геологийн нөөц

“Хойд өндөр хошуу-1” элсний ордын геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 211.23 мян.м³, боломжтой (С) зэрэглэлээр 90.42 мян.м³, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 301.65 мян.м³-ээр тооцож ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Хүснэгт 3. “Хойд өндөр хошуу-1” барилгын элсний ордын батлагдсан геологийн нөөц

№	Блокийн дугаар, нөөцийн зэрэглэл	Блокийн талбай, м ²	Хөрсний дундаж зузаан, м	Элсний дундаж зузаан, м	Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м ³	Элсний нөөц, мян.м ³
0	1	2	3	4	6	7
Бодитой (В) зэрэглэлийн нөөцийн блокууд						
1	1-В	12719.26	0.19	1.94	2.38	24.64
2	2-В	15955.6	0.15	1.76	2.39	28.02
3	3-В	17582.58	0.12	2.03	2.15	35.65
4	4-В	24493.31	0.12	1.95	2.83	47.76
5	5-В	25769.84	0.11	1.8	2.78	46.48
6	6-В	18554.66	0.1	1.55	1.86	28.67
-	Дундаж	-	0.13	1.84	-	-
Бодитой (В) зэрэглэлийн нийт нөөц					14.38	211.23
Боломжтой (С) зэрэглэлийн нөөцийн блокууд						
7	1-С	3794.85	0.18	2.06	0.68	7.82
8	2-С	2328.52	0.2	1.65	0.47	3.84
9	3-С	2647.75	0.15	1.38	0.4	3.64
10	4-С	2665.02	0.1	1.33	0.27	3.53
11	5-С	2323.95	0.1	1.05	0.23	2.44
12	6-С	2674.98	0.1	1.1	0.27	2.94
13	7-С	2476.58	0.1	1.0	0.25	2.48
14	8-С	45418.01	0.1	1.24	4.54	56.09
15	9-С	6943.56	0.1	1.1	0.69	7.64
-	Дундаж	-	0.12	1.23	-	-
Боломжтой (С) зэрэглэлийн нийт нөөц					7.8	90.42
Ордын нийт бодитой болон боломжтой (В+С) нөөц					22.18	301.65

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

“Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний ордын батлагдсан геологийн нөөцийн бодитой (В) зэрэглэлийн нөөц болон уурхайн хүрээнд зайлшгүй байдлаар өртөж байгаа боломжтой (С) зэрэглэлийн нөөцийн блокуудыг тус тус ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөж уурхайн эцсийн хүрээг загварчилсан.

Ил уурхайн хүрээнд бодитой (В) зэрэглэлийн нөөцийн блокоос нийт 211.23 мян.м³ элсний нөөц, боломжтой (С) зэрэглэлийн нөөцийн блокоос нийт 0.89 мян.м³ элсний нөөц тус тус олборлогдохоор байна. Энэхүү нөөцийг ил аргаар ашиглах үеийн нийт хаягдал 5.45% (11.57 мян.м³) байхаар тооцоход нийт үйлдвэрлэлийн нөөц нь магадалсан (В') зэрэглэлээр 200.55 мян.м³ болохоор байна.

1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим

Уурхайн хүчин чадал: Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 13.49 мян.м³ 70.0 мян.м³ элс олборлон боловсруулахаар тооцож тусгасан байна.

Уурхайн ажиллах горим: Уурхайн уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд 11-р сарын 01-ээс 3-р сарын 31-ийг хүртэл өвлийн улирлын сул зогсолт, 4-р сарын 01-ээс 10 сарын 31-ийг хүртэл олборлолтын үйл ажиллагаа явагдах бөгөөд жилд 6 сар ажиллана.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим, хүчин чадал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Сул зогсолтын хоног	хоног	207
3	Уурхайн жилд ажиллах хоног	хоног	158
4	Баяр ёслолын амралт	хоног	7
5	Цаг агаарын саатал	хоног	5
6	Төлөвлөгөөт засвар, үзлэг	хоног	12
7	Төлөвлөгөөт бус засвар	хоног	6
8	Бэлтгэл ажил	хоног	3
9	Жилд ажиллах бодит хоног	хоног	125
10	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1.0
11	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8.0
12	Ээлжин дэх сул зогсолт	цаг	1.0
13	Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг	цаг	7.0
14	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.88
15	Хоногт ажиллах бодит цаг	цаг	7.0
16	Жилд ажиллах бодит цаг	цаг	875
17	Уурхайн цагийн хүчин чадал	м ³ /цаг	80.0
18	Уурхайн ээлжийн хүчин чадал	м ³ /ээлж	560.0
19	Уурхайн хоногийн хүчин чадал	м ³ /хоног	560.0
20	Уурхайн жилийн хүчин чадал	мян.м ³ /жил	70.0

1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал

“Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах үндсэн ажилбаруудаар гүйцэтгэгдэнэ.

ЭЛС ОЛБОРЛОЛТ:

ХУЧААС ХӨРС ХУУЛАЛТ ► ЭЛС ОЛБОРЛОЛТ ►
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ

Үүний зэрэгцээ уурхайн зам цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилттой тэмцэх мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд тодорхой хувиар, зохион байгуулалтын дагуу хийгдэнэ.

БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамалшил, амьтны аймгийн хам бүрдэл, тэдгээрийн хоорондын ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцөлүүдээр нь 3 муж, 5 тойрог болгон мужилсан байдаг.

Хүснэгт 5. Өмнөговь аймгийн газар нутгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор мужлал

№	Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай, га
1	Говийн Алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5)	285362.4
		Гурвансайхан уулсын тойрог (Г-6)	2237586.4
2	Алтайн өвөр говийн цөлийн муж	Алтайн өвөр говийн тойрог (Г-8)	4660120.5
3	Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойд хэсгийн тойрог (Г-9)	3263476.8
		Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)	6091501.0
-	Нийт		16538047.0

MV-46000205 дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өндөр хошуу” нэртэй талбай нь Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрог (Г-10)-т хамаарч байна.

2.1. Уул зүй

Дорнод говийн цөлөрхөг мужийн гадаргын хувьд ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар гол суурийг эзлэх бөгөөд говийн зүүн хэсэгт байгаа уулс харьцангуй намхан, өндөр нь 1300-1800 метрээс үл хэтэрнэ.

Дорнод говийн өмнөд хэсгийн тойрогт (Г-10)-т уул, толгод нэлээн түгээмэл. Нам уулс, цав толгод зүүн хойш намссаар талархаг буюу хужир марцат хотгоруудад шилжин түүний бэлээр цэрдийн болон гуравдагч галавын элсэнцэр хурдас тархаж, цав толгод зүүн хойш суналтай нэгэн суурь бүхий дэл үүсгэж тогтсон нь олонтой тохиолдоно.

Ордын талбай орших Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгай хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул (д.т.д 1295 м), Далайн дуулга (д.т.д 1240 м) зэрэг уулс орно.

Мөн 100-130 км үргэлжилсэн Галбын говь, Дайчингийн говь, Сэвхүүлийн хоолойн элсэн далан, заган шугуй, Уртын гол, Ундайн гол, Халзан хайлаастын гол зэрэг хайлаасан зурвасуудтай, янз бүрийн хэлбэр дүрс бүхий боржин чулуун цохиотой. Тогоо, Гурван зээрд, Ухаа аргалантын агуйнууд зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.

Дорнод говийн цөлөрхөг мужид ухаа гүвээт тал дундах жижиг хотсоос гадна том хэмжээний хотгорууд хотгор гүдгэрт нь чухал суурийг эзэлнэ. Тийм хотгор дорнод говийн зүүн хагаст голчлон оршихдоо нийтдээ зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон байна. Түүний ёроол тэгш биш, хэд хэдэн чиглэлд хэвгий учир хоёрдугаар зэргийн хотгорууд бий болно. Хотгорын хажуу нилээн налуу боловч гуу жалгаар хэрчигдэж зарим газарт нь бяцхан оорцог дов, толгод ч үзэгдэнэ.

Хоёрдугаар зэргийн хотгоруудын ёроол төв хэсэг рүүгээ хэвгийгээс гадна гадаргад нь бас жижиг гүвээ, толгод хааяа илэрсэн байна. Элс энд тэнд тархана. Хамгийн нам дор газрууддаа бага хэмжээний нуур, хужир марц, шал тойром тогтсон байна.

2.2. Усан сүлжээ

Ордын талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тус тус багтана. Байнгын урсгалтай гол, горхи байхгүй, хуурай сайр, тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрэх ба богино хугацаанд хөрс болон агаарт шингэн ууршдаг.

Хүн, малын ундны хэрэгцээнд голчлон худгийн ус хэрэглэх ба багаар булаг шандны ус ашиглагддаг. Гар болон өрөмдмөл гүний худгууд гаргасан байдаг бөгөөд эдгээрийн гүн нь дунджаар 2 м, ундарга нь 220 л/ц орчим, эрдэсжилт, хатуулаг, хужир мараа ихтэй. Ордын талбайд хамгийн ойр орших уст цэг нь баруун хойд зүгт 7 км-т байрлах өрөмдмөл гүний худаг байна.

2020 оны усны тоо бүртгэлээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт нийтдээ 32 булаг, 86 нуур, тойром, 182 худаг бүртгэгдсэн байна.

Гүний усны хувьд энэ бүс нутагт Цавчир элс, Хар заг, Гүний хоолой, Галтын заг, Тэсэгний зоо гэх газруудад Палеогений сэвсгэр хурдас дахь уст үе, цогцолбор (E_{2ez}), Мезозойн тунамал хурдас дахь уст үе, цогцолбор (sMZ) тогтоогдсон байна.

2.3. Уур амьсгал

Дорнод говийн цөлөрхөг мужид жилийн дундаж агаарын температур 2-4°C орчим байна. Мужийн хойд хэсгээр арай сэрүүн, 2°C байдаг бол өмнө талдаа 4°C ба түүнээс их байна. 7 дугаар сарын дундаж агаарын температур 21.4-22°C, зуны хамгийн их температур 30°C-аас дээш байх өдрийн тоо 24-26 байна. Хавар дунджаар 5 дугаар сарын 10-даар цочир хүйтрэл дуусч, намар 9 дүгээр сарын 25-дын үеэр анхны цочир хүйтрэл болж эхэлнэ. +10°C-аас дээших идэвхитэй температурын нийлбэр дунджаар 2500°C байдаг. 1 дүгээр сарын дундаж агаарын температур -16 -18°C орчим байна. Жилийн нийлбэр тунадасны хэмжээ 100-120 мм, үүнээс дулааны улиралд ихэнх нь унана.

Дулааны улиралд арав хоног тутам харьцангуй чийгшил 30% ба түүнээс доош байх өдрийн тоо 4-7 өдөр буюу дулааны улирлын нийт хоногийн 50%-д нь хуурай байдаг учир ууршил их явагдах нөхцөлтэй.

Салхины дундаж хурд 4-6 м/с, хавар намартаа хүчтэй салхи, шороон шуурга ихтэй байдаг бөгөөд салхины хурд дунджаар 30-35 м/с хүрч, 2-5 хоног үргэлжлэх үе ч байдаг. Салхины голлох чиглэл нь баруун ба баруун хойноос байна.

2.4. Ургамалан нөмрөг

Дорнод говийн цөлөрхөг муж нь ургамалжилтын хувьд тачирхан, сийрэг ургамалтай, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт хээр зонхилно. Шавранцар хайргархаг бэлээр баглуурт бор бударганаас гадна хайргархаг-элсэнцэр хөрстэй газраар нь, ялангуяа өмнөд хэсгийн нутгаар хойргот, тостот, модлог бударганат, тэсэгт цөл зонхилно. Элсэрхэг хөрстэй газраараа сийрэгхэн загийн шугуйтай, эсвэл харгана-шавагт эвшил тааралдана.

Шаварлаг марцлаг хотгоруудад гоолиг шар бударгана, Зүүнгарын улаан бударгана, эсвэл луулийн овгийн нэг наст ургамлууд оролцсон эвшлүүд тохиолдоно. Энэ мужийн нутгуудаас Баянзагийн хотгор бол Монголын цөлөрхөг хээр дэх өвөрмөц газрын нэг бөгөөд тэнд говийн бараг бүх элементүүд хуран цуглажээ.

Дорнод говийн цөлөрхөг мужид одоогоор 327 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 68 зүйл (мужийн ургамлын 20.8%) модлог, сөөглөг ургамал, 259 зүйл өвслөг (79.2%) ургамал байна. Энэ задлагаас үзэхэд мод, том сөөг тун цөөн, харин ердийн сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөг, сөөгөнцөр бусад өвслөг ургамлынхаа зүйлийн тоогоор Алтайн өвөр говийн мужтай тун ойролцоо юм.

Ургамалын экологийн үндсэн бүлгүүдийг авч үзвэл хуурайсаг ургамал 70 зүйл (21.41 %), давссаг 4 бүлгийн 64 зүйл ургамал (19.57%), элссэг 20 зүйл ургамал (10.93%), хуурайсуу-чийгсэг 35 зүйл ургамал (10.7%), чийгсэг 24 зүйл ургамал (7.34%), хуурайсуу-намагсаг 6 зүйл ургамал (1.84%) байна. Харин ус, намгийн ба хүйтсэг ургамал байдаггүй. Их хуурай халуун болон давсархаг марцлаг газарт зохилдсон ургамлууд ургамлын нөмрөгт голлох үүрэг гүйцэтгэнэ.

Дорнод говийн өмнөд хэсгийн тойргийн ихэнх хэсэг болох Заг Сүүжийн говь, Борзонгийн говь, Галбын говь, Өөшийн говь, Борхойн тал нь мараалаг бор, бор саарал хөрстэй бор бударганат, бор саарал ба цөлөрхөг хээрийн давсархаг бор хөрстэй заг-давслаг сөөгт бэлчээртэй. 1.5-2 ц/га тэжээлийн нөөцтэй, 90-120 кг/га тэжээлийн нэгжтэй.

2.5. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Дорнод говийн цөлөрхөг мужийн хөрсөн бүрхэвчийн 70 орчим хувьд цөлийн болон хээржүү цөлийн, толгодын бор саарал хөрс тархах ба ердийн болон толгодын сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс 20 орчим хувьд нь тархаж байна.

Нам хотосуудаар жинхэнэ хужир, шал хөрс тархана. Шал, элсэн хөрс 4 орчим хувийг эзэлж байна. Цөлийн бор саарал хөрсний ургамлан бүрхэвч маш сийрэг үүнээс шалтгаалан энэ хөрсний үржил шим, агро үйлдвэрлэлийн чадавхи үлэмж муу, усны элэгдлийн нөлөөгөөр гадарга нь ихээхэн атираажиж, өнгөндөө гандаасан хучаас тогтсон байдаг.

Ордын талбай орших Ханбогд сум нь говийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний бүст хамрагдана. Тус сумын нутаг дэвсгэрийн хөрс нь үндсэндээ сул хөгжилтэй, говийн сийрэг тархсан (бүрхэц 8-25%) ургамлан нөмрөгийн дор бүрэлдэн тогтсон хөрс зонхилно. Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0 хувиас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч, хөрсний давхарга бүрт харилцан адилгүй байна. Цөлийн бор саарал хөрс бүрэлдэх явц нь бусад төрлийн хөрснүүдээс ялгаатай байдаг. Учир нь говийн хуурай цаг уур болон ховор тохиолдох хур тунадас зэргээс шалтгаалж хөрсний 80.0 хувь нь эрдэсжсэн байдаг.

Хөрсний шинж чанар нь натрийн карбонат, бусад хэлбэрийн карбонат, ууссан давс, шохойлогтой эсэхээс хамаарч тодорхойлогдоно. Судлаачид говийн хөрс тогтворжиход хөрсний чийгийн горим их нөлөө үзүүлсэн гэж үздэг. Түүний нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг дээр карбонат, биокарбонат хуримтлагдаж, давс агуулсан нимгэн шаварлаг үе бий болдог.

Говийн хөрс нь өвлийн цагт өнгөн хэсэгтээ 1-1.5 м гүнд хүртэл хөлдөнө. Улирлаас хамааран жилд 6-7 сарын турш урт удаан хугацаанд хөлдөнө. Дулааны улиралд бороо чийг ихтэй үед хөрсөн дэх биологийн идэвхи ихээхэн дээшилдэг.

Давсны өндөр агууламж, органик бодисын бага агууламж, хөрсний шүлтлэг чанар нь хөрсийг салхи, усны элэгдэлд амархан өртөх болон хурдан тархахад хүргэдэг. Энэ нь тухайн нутаг дэвсгэр элэгдэл, эвдрэлд өртөхөд голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл болно

2.6. Ан амьтад

Дорнод говийн цөлөрхөг мужид нийтдээ 4 ангийн 131 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20.1% нь оршин амьдардаг байна.

Энэ мужид 5 баг, 11 овогт хамаарах 44 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 31.6% болно.

Дэлэнтний дийлэнх хэсгийг мэрэгчтэний багийн амьтад эзлэх бөгөөд (23 зүйл буюу энэ мужийн дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 52.2%) үндсэндээ Төв Азийн цөл, хээрийн гаралтай амьтдаас бүрдэнэ. Зүйлийн бүрэлдэхүүний хувьд Алтайн өвөр говийн тойргийн дэлэнтэн амьтдынхтай төстэй.

Олон улсын ба Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан юмуу Улаан номонд орсон амьтдаас цоохор ирвэс, эрээн хүрэн, хар сүүлт, янгир ямаа, аргаль хонь зэрэг 5 зүйл энэ мужийн нутаг дэвсгэрт амьдарна.

Дорнод говийн цөлөрхөг муж бол цагаан зээрийн нэг үндсэн тархац нутаг юм. Судалгааны дүнгээс үзвэл Дорноговь аймгийн Хатанбулаг чиглэлд 2037 км замлалд 23340 цагаан зээр тоолж 1 км-д 11.4 толгой, Алтанширээ чиглэлд 1750 км замлалд 16676 цагаан зээр тоолж, 1 км-д дунджаар 10.45 толгой цагаан зээр ноогдох нягтшилтай байна.

Энэ мужийн нутаг дэвсгэрт нийт 10 баг, 22 овгийн 76 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлнэ (36 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 47.3%). Энэ мужид шонхор хэлбэртний багаас 11 зүйл (14.4%), хөгчүү хэлбэртний багийн 19 зүйл (25.0%) тус тус оршин амьдарна. Ус намгийн амьдралтай шувууд тун ховор.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орсон 14 зүйл шувуу (сохор элээ, морин харцгай, шилийн сар, тарважи бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, начин шонхор, хилэн жигүүрт, шар шувуу, хотны бүгээхэй, хулан жороо) тус мужийн нутаг дэвсгэрт бүртгэжээ.

Мөлхөгчидөөс энэ мужид 1 баг, 5 овгийн 10 зүйл тэмдэглэжээ. Улаан номон орсон нарийн могойноос бусад зүйл нь түгээмэл тархалттай, элбэг тохиолдох амьтад юм. Хоёр нутагтанаас зөвхөн монгол бах тэмдэглэгдсэн ба тоо толгойн хувьд хэвийн хангалттай байна.

2.7. Хүн ам, дэд бүтэц, эдийн засаг

Ордын талбайд хамгийн ойр орших суурин газар нь Өмнөговь аймгийн Ханбогд сум бөгөөд тус сум нь 2023 оны байдлаар 8404 хүн ам, 2116 өрхтэй, Оюу Толгойн уурхайн их бүтээн байгуулалтыг дагаад эрчимтэй хөгжиж буй сум юм.

Тус суманд Оюу Толгойн алт зэсийн бүлэг орд гэх мэт зэс, алт, төмрийн орд байхаас гадна дэлхийд ховор Армострон болон Монголит зэрэг газрын ховор элементүүд, барилгын материал, палеонтологийн олдвороор элбэг юм. Сумын нутаг дэвсгэрт багтах Гашуун Сухайтын боомт нь ард иргэдэд ойр учраас зах зээл хөгжих, иргэдийн аж ахуй амьдрал дээшилхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Сумын төв нь 2018 онд Оюу Толгойн уурхайтай 35.1 км хатуу хучилттай авто замаар холбогдсон. Мөн 2018 онд 1.8 мегаватт хүчин чадалтай уурын зуухны өргөтгөл ашиглалтанд орсноор сумын дулаан эрчим хүчний найдвартай эх сурвалжтай болсон.

Сумын ИТХ, ЗДТГазар нь 38 албан хаагчтайгаар төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ханбогд сумын ЕБС нь 2 хичээлийн байртай ба 1156 сурагч, 105 багш ажилчидтай.

Мөн 21, 22, 29-р цэцэрлэгт 718 хүүхэдтэй бөгөөд 79 багш ажилчид ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна. Онцгой байдлын Гал түймэр унтраах, аврах 66-р анги, 350, 160 хүний суудалтай соёлын төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн тасаг, 50 ортой сум дундын эмнэлэг, Сум дундын шүүх, Сум дундын 1-р прокурор, Хандизель, Ханбогд хот тохижилт зэрэг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, ХААН банк, Хадгаламж банк, Хас банк, Голомт банк, Капитрон банкны салбарууд зэрэг хувийн хэвшлийн 300 гаруй аж ахуйн нэгж, 60 гаруй дэлгүүр, супермаркет, 30 орчим цайны газар, ресторан, зочид буудал үйл ажиллагаа явуулж байна.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Гол сөрөг нөлөөллүүд:

- Элс олборлох үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт РМ10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа шороон зам нь агаарт тоосжилт үүсэх.
- Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдснаас агаарт химийн бодис ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

3.2. УСНЫ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Гол сөрөг нөлөөллүүд:

- Уурхайн олборлолтын явцад шүүрлэлтийн усыг шавхаснаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Уурхайн хотхон болон ажилчдын кемпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

3.3. ХӨРСНИЙ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Гол сөрөг нөлөөллүүд:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс элээгдэл, эвдрэлд орох.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлын зөвөөрөлгүй газар хаяснаас хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаа бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

3.4. УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

Гол сөрөг нөлөөллүүд:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх.

3.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Гол сөрөг нөлөөллүүд:

- Уул уурхай, түүнийг дагасан суурьшлын бүсээс тухайн бүс нутгийн амьтад дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтдын амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Тээврийн зам хөндлөн гарах амтад машинд дайруулах

БҮЛЭГ-4. “ХОЙД ӨНДӨР ХОШУУ-1” ЭЛСНИЙ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Зорилго: “Дэйзэрт бридж” ХХК-ийн “Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

“Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **6,000,000.0** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвчид төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- ✓ Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- ✓ БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалаллын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Хойд өндөр хошуу-1” нэртэй элсний ордын төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ургамлан нөмрөгийн хяналт, шинжилгээ:

Уурхайн үйл ажиллагааны явцад ургамлын аймаг, ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээ, судалгааг сонгосон цэгүүдэд, тодорхой давталттайгаар, тогтмол явуулсанаар цөлөрхөг хээрийн өвөрмөц экосистемд дасан зохицож ирсэн ургамлан нөмрөг, түүний зүйлийн олон янз байдлын хомсдолыг хянах, ургамлын бүлгэмдэлд өөрчлөлт орж байгаа эсэх, хөл газрын ургамлын оролцоо нэмэгдэж байгаа болон ургамлын бүтээмж хэрхэн өөрчлөгдөж байгаа зэргийг илрүүлэх боломжийг олгоно. орд нь байгаль орчны салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, стандарт, журам зэрэг эрхзүйн баримт бичгүүдээс өөрсдийн үйл ажиллагаатай холбоотойг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Уурхайн талбайд ургамлан нөмрөгийн мониторингийн цэг сонгон авч ургамлын хяналт-шинжилгээ, мониторингийн судалгааг тогтмол хийх хэрэгтэй.

Хяналт шинжилгээг явуулахдаа сонгон авсан цэгүүдэд аргагүйн дагуу тодорхой хуваариар хэмжилт бүртгэл хийх ба ургамлан нөмрөгт олборлолтын болон байгалийн зүгээс үзүүлж буй нөлөөг тогтоох шаардлагатай. Хяналтын цэгийг сонгохдоо ургамлан бүлгэмдэл солигдлын дагуу шугаман трансектийн дагуу явж ургамлан бүлгэмдэл өөрчлөгдөх тутамд хяналтын цэг сонгоно. Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээг ургамлын өсөлт хөгжлийн үе буюу 6-8 сард хийнэ. Ингэхдээ сонгосон хяналтын цэгт 3 удаагийн давтамжтайгаар геоботаникийн бүрэн бичиглэлийг Браун Бланкийн бичиглэлийн аргаар үйлдэнэ. Бичиглэлд ургамлын төрөл зүйл, тохиолдоц, арви, бодгалийн тоог үнэлнэ. Мөн бүлгэмдлийн биомассыг хуурай жингийн аргаар тодорхойлно. Хяналт шинжилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлэх. Үүнд:

- Хөндлөнгийн-Мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- Дотоод-Уурхайн байгаль орчны мэргэжилтнүүд хийх,
- Олон нийтийн оролцоотой хийх зэрэг болно.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тусгай зориулалтын бодис хэрэглэх	Ил уурхай	м ³ /сар	Жил бүр	1 000 000		Дэйзэрт бридж ХХК	-	Шаардлагатай нөхцөлд усалгаа хийгдсэн байх	Агаарын тухай хууль, MNS 4585:2007
2	Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах		м ³					Өдөр бүр	Үйлдвэрлэлийн зардлаас	
3	Уурхайн тээврийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах		-	Үйлдвэрлэлийн зардлаас	-					
4	Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах	Төслийн талбайн хөнгөн тэрэгнүүд	ширхэг	10	Үйлдвэрлэлийн зардлаас		Байгаль орчны баг	Улсын үзлэгт хамрагдаж Холбогдох төлбөрийг төлсөн байх	АТ Хууль АБТТ Хууль	
5	Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх	уурхайгаас Засмал зам хүртэл зам	80 км	Тухай бүр	Үйлдвэрлэлийн зардлаас		Байгаль орчны баг	Шороон замаар тээвэр хийсэн тохиолдол гараагүй байх	БОХТ Хууль	
БОМТ-ний зардал, төг								1 000 000		

Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Газар доорх усны хяналт шинжилгээг малчдын худгууд дээр хуваарийн дагуу хийж гүйцэтгэх	Уурхай орчим	хүн/ өдөр	2	Орчны хяналт шинжилгээний зардлаас		Дэйзэрт бридж ХХК	Усны лабораториуд	Хэмжилт, дээжлэлт хуваарийн дагуу хийгдсэн байх	БОНБҮТХ
2	Булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах	Төслийн талбай орчмын уст цэгүүд	хүн/ өдөр	2	100.0	200 000		Төслийн нэгжүүд	Жилд 3-с доошгүй уст цэгүүдийг цэвэрлэсэн байх	Усны тухай хууль
БОМТ-ний зардал, мян.төг					200 000					
Үйлдвэрлэлийн зардал					-					

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллана.	Төслийн талбай	удаа	4	100000	400000	Байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Хөрсний шинжилгээний дүн стандартын шаардлага хангаж байх	ХХЦСТ Хууль, MNS 5850:2008
2	Салаа зам үүсэхээс хяналт тавьж, хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ	Төслийн талбай	хүн/өдөр	4	100000	400000	Байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Төслийн нөлөөллөөр салаа зам гараагүй байх	ХХЦСТ Хууль, ГТХууль
3	Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх	Уурхайн орчмын бүс	Удаа	2	Орчны хяалт шинжилгээний зардлаас		Байгаль орчны баг	Мэргэжлийн байгууллага	Шинжилгээний дүн, Тайлан гарсан байх	БОНБУТХ MNS 5850:2008, MNS 3297:1991
4	Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингээгдэхээс сэргийлж үерийн ус зайлуулах суваг, шуудуу байгуулах	Төслийн талбай болон түүний орчимд	-	-	-	Үйлдвэрлэлийн зардлаас	Уулын үйлдвэрлэлийн хэсэг, байгаль орчны баг	Төслийн нэгжүүд	Үйлчлэлийн нөлөөгөөр	
БОМТ-ний зардал						800 000				
Үйлдвэрлэлийн зардал						-				

Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Удаа	1	Төсөл хэрэгжүүлэгчийн дотоод зардал		Мэргэжлийн судлаач, байгууллага	Байгаль орчны баг	Тайлан гарсан байх	БОНБҮТ Хууль
2	Амьтны аймгийн мониторинг судалгааг том хөхтөн амьтан, шувууд зэрэг чиглэлээр хийж хэрэгжүүлэх	төслийн талбай	Удаа	1			Мэргэжлийн судлаачид, байгууллага	Байгаль орчны баг	Тайлан гарсан байх	БОНБҮТ Хууль
БОМТ-ний зардал, мян.төг						-				
Үйлдвэрлэлийн зардал						-				
Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний нийт зардал, мян.төг						2 000 000.0				

4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ашиглалтын эхний жилд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй тул зардал төлөвлөх шаардлагагүй болно. Уурхай нь 2024 онд оны төгсгөлд 1 сар буюу богино хугацаанд ажиллана.

4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2024 онд оны төгсгөлд 1 сар буюу богино хугацаанд ажиллах тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн зардал төлөвлөөгүй ба 2025 оны үйл ажиллагаанд нөхөж тусган ажиллана.

4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайн ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх болон ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх шаардлагатай зүйлс байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй болно.

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, археологи, палеонтологийн олдвор тогтоогдоогүй.

Цаашид уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан, хиргэсүүр зэрэг археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд Соёлын өвийг хамгаалах үүднээс төслийн үйл ажиллагааг түр зогсоож хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлэх шаардлагатай.

4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Дэйзэрт бридж” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Уурхайн ажлын явц дахь болзошгүй осол	Анхааруулсан тэмдэг тавьж байрлуулах	Төслийн талбай	Дотоод төлөвлөлтөөр			2024-2028	
2.		Аюулгүйн тууз татах					2024-2028	
3.	Хийн тоног төхөөрөмжийн буруу сууриулалт	Технологийн заавар, аюулгүй ажиллах журмыг нарийн мөрдөх, Галын аюулаас сэргийлэх		Дотоод төлөвлөлтөөр			2024	
4.	Шатах тослох материалын асгаралт	Машин зогсоох талбайг хайргажуулан нягтруулах					2024-2028	
5.	Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх.		Дотоод төлөвлөлтөөр			2024-2028	ХХБАБТХ
	Нийт						-	

4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам болон үйлдвэрлэлийн хэрэгцээтэй газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь хэтэрхий удаан байдаг учраас байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй байдаг.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

#	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Аюултай хог хаягдлыг паспортжуулах	Төслийн хүрээнд	ш	2	20000	40000	“Дэйзэрт Бридж” ХХК	Уул ба засварын хэсэг	Аюултай хог хаягдлын паспорттай болсон байна.	Аюултай хог хаягдлыг паспортжуулах журам
2	Аюултай хаягдлын бүртгэлийг бий болгох	Төслийн хүрээнд	хүн/цаг	4	10000	40000		Уул ба засварын хэсэг	Бүртгэлийг тогтворжуулан мэдээллийн сан үүсгэсэн байх	Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай хог хаягдлыг ангилан ялгах сурталчилгээг ажилчдад өгөх	Нийт ажилтан ажиллагсад	удаа	1	70000	70000		Уул ба засварын хэсэг	Мэдээлэл хүргэгдсэн байх	Хог хаягдлын тухай хууль
4	Хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбайд	удаа	5	50000	250000		-	Цэвэрлэгээ зохион байгуулагдсан байх	Хог хаягдлын тухай хууль
5	Хог хаягдлын битүүмжлэх бүхий цэгүүдийг байгуулах	Төслийн талбайд	ш	2	100000	200000		-	Хийгдсэн байдлаар	-
6	Хог хаягдлын зайлуулах үйл ажиллагаа	Төслийн талбай	удаа	12	100000	1200000				
БОМТ-ний зардал, мян.төг						1 800 000				

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Дэйзэрт бридж” ХХК-ний элсний уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“Дэйзэрт бридж” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Шинжилгээний нэрс	Хийлгэх тоо	Нэг бүрийн үнэ	Нийт зардал /төг/	тайлбар	Хаана
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Тоосонцор-TSP(их эзэлхүүний арга)	8	30000	240000		Байгаль Орчин, Хэмжилзүйн төв лаборатори
2	Агаарын найрлагыг тогтоох хэмжилт	8	30000	240000		
Нийт				480 000		
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Хөрсний анхан шатны боловсруулалт	12	5000	60000	Нийт дээжийг хөрсний 2 үе давхаргаас авч шинжлүүлнэ.	ШУА-н Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын сектор
2	Аммони	12	8300	99600		
3	Фосфор	12	9000	108000		
4	Нитрат	12	8600	103200		
5	Сульфат	12	3300	39600		
6	чийг	12	2000	24000		
7	РН	12	2100	25200		
8	Ялзмаг	12	5000	60000		
10	Хүнд элементийн шинжилгээ	4	50000	200000	12 элемент	Байгаль Орчин, Хэмжилзүйн төв лаборатори
Нийт				719 600		
Газрын доорх усны хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Усан орчин /рН/	4x2	700	5600	Жич: 2 цэг	
2	Ууссан хүчилтөрөгч /O2/	4x2	2400	19200		
3	Хатуулаг	4x2	900	7200		
4	Хлорын ион /Cl/	4x2	1300	10400		
5	Нитритийн азот /NO2/	4x2	2100	16800		
6	Нитратын азот /NO3/	4x2	3000	24000		
7	Гидрокарбонатын ион /HCO3/	4x2	1500	12000		
8	Эрдэсжилт	4x2	700	5600		
9	Хүнд элементийн шинжилгээ	4x2	50000	400000		
Нийт				500 400		
Нийлбэр дүн				1 700 000		

4.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Дэйзэрт бридж” ХХК-ний элсний уурхайн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Байгаль орчны асуудалд зөвхөн байгаль орчны мэргэжилтэн анхаарал хандуулах биш шаврын орд болон үйлдвэрийн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүнд:

- ✓ Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- ✓ Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- ✓ Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана,
- ✓ Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 17. Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	Жил бүр	Дотоод зардал	Мэргэжлийн байгууллага	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Жил бүр	Дотоод зардал		
3	Гал тогооны хэсэгт ажиллах хүн бүрийг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Хагас жилд	Дотоод зардал		
4	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах	Жил бүр	500 000	онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн аюул, эрсдэлээс бүрэн сэргийлэх
5	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	2 жил тутамд	дотоод төлөвлөлтөөр		
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах	Жил бүр	Харилцан тохиролцсноор	БОННУ хийх мэргэжлийн байгууллага	Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж авах
7	Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд		БОА хийх мэргэжлийн байгууллагууд	
	Дүн		500 000		

4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

"Дэйзэрт бридж" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 18. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

#	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа	Тайлан мэдээлэл хүлээн авах тал	Тайлагнах хэлбэр	Тайлганах огноо	Нийт зардал мян.төг	Хэрэгжүү - лэгч	Хамтран хэрэгжүү -лэгч	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	БОАЖЯам, Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан	Бичгээр	11 сарын 01-нд	-	"Дэйзэрт бридж" ХХК	-	Аймгийн БО-ны газраар дүгнэлт гаргасан, тайлан дүгнэлтийн хамт БОАЖЯ-д хүргэгдсэн байна.
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хагас жилийн тайлан	Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан	Бичгээр	07 сарын 20-ны дотор	-		-	Холбогдох газарт тайлан хүргэгдсэн байна.
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн сар бүрийн хэмжилтийн мэдээлэл	Компанийн удирдлагууд	И-мэйл	Сар бүрийн эхний 5 хоног	-		-	Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна.
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сар бүрийн биелэлт, БО-ны багийн үйл ажиллагааны тайлан	Компанийн удирдлагууд	И-мэйл	Сар бүрийн эхний 5 хоног	-		-	Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна.
5	Нөлөөллийн бүсийн иргэдийг Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл танилцуулах	1-р багийн иргэд	Танхимын мэдээлэл ба хээрийн хэмжилтэнд оролцуулах	10 сарын 20	-		Орон нутгийн харилцаа -ны баг	Жилд 1 удаа зохион байгуулагдсан байна.

4.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

“Дэйзэрт бридж” ХХК-ийн 2024 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2024 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 6,000,000.0 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө

Хүснэгт 19. Төслийн 2024 оны БОМТ-ний зардлын нэгтгэл

№	Арга хэмжээ	Зардал' төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2'000'000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Эхний жилд хийгдэхгүй
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2024 онд төлөвлөөгүй, 2025 онд нөхөж гүйцэтгэнэ
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Шаардлагагүй
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төлөвлөөгүй
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Дотоод зардлаар гүйцэтгэнэ
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1'800'000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1'700'000.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500'000.0
10	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		6'000'000.0

ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Дэйзэрт бридж” ХХК-ний “Хойд өндөр хошуу-1” элсний уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Элс олборлох үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын ба геологийн тогтоц юм. Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллах шаардлагатай.

Уурхайн нь 2024 онд оны төгсгөлд 1 сар буюу богино хугацаанд ажиллах тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн зардал төлөвлөөгүй ба 2025 оны үйл ажиллагаанд нөхөж тусган ажиллана.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 6'000'000.0 (Зуургаан сая) төгрөг зарцуулахаар гарсан байна.

“Дэйзэрт бридж” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал дахь нөхөн сэргээлтийн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын 50% буюу **3'000'000.0 төгрөг (Гурван сая) төгрөгийг Ханбогд сумын тусгай дансанд байршууллаа.**

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. “Дэйзэрт бридж” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжих MV-46000205 тоот тусгай зөвшөөрлийн талбайд “Хойд өндөр хошуу-1” нэртэй барилгын элсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, Энвишнгрин ХХК, 2024 он
2. Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журам
3. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - www.legalinfo.mn
4. Байгаль орчны мэдээллийн сан - www.eic.mn